



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 4/25

Амардалай

Ахмадуудад дуудлагаар үйлчилгээ үзүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сумын Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сар шинийн баяр тохиож байгаатай холбогдуулан ахмадуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, ахмадын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин ажиллах зорилгоор сумын төвийн хэмжээнд ахмадуудад үйлчилгээ үзүүлэх дуудлагын машиныг 2022 оны 01 дүгээр сарын 12-оос 01 дүгээр сарын 28-ны ажлын өдрүүдэд зохион байгуулсугай.

Хоёр. Ахмадуудад дуудлагаар үйлчилгээ үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулж, үйлчлэх жолооч, цагийн хуваарийг хавсралтаар баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: С.Нарантунгалаг (ЗДТГ-ын дарга)

Гишүүд: П.Амгаланбаатар (Баянбулаг багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (Цахиурт багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (Дэлгэр-Эмт багийн Засаг дарга)

Гурав. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн холбогдох зорилтуудын хэрэгжилтийг хангуулан үр дүнг тайлагнан ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Золжаргал), шаардагдах тээврийн хэрэгсэл, шатахууны зардлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг Засаг даргын тамгын газрын дарга (С.Нарантунгалаг) нарт тус ус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ



4880200465

